Тайлант онд Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, ЭХЗХ-ны 2022 оны 504, 514 дугаар тогтоолоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс цахилгаан эрчим хүчний тарифт өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзсэн.

Эрүүл мэндийн газарт хяналт, үнэлгээ шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн ажилладаг бөгөөд дотоод аудитын нэгж хариуцсан ажилтан байхгүй байна. Эрүүл мэндийн яамны дотоод аудитын нэгжээс дотоод аудитыг хэрэгжүүлдэг. 2023 онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх иийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130,107.2 мянган төгрөгөөр бууу 7.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3-2-1
Мөнгөн хөрөнгө	9,778.5	21,891.4	12,112.9
Авлага	0,0	24,000.0	24,000.0
Бараа материал	260,417.4	207,863.0	-52,554.4
Үндсэн хөрөнгө	1,094,813.7	1,008,148.0	-86,665.7
Нийт хөрөнгийн дүн	1,365,009.6	1,261,902.4	-130,107.2
Нийт өр төлбөр	0,0	0,0	
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,365,009.6	1,261,902.4	-130,107.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,365,009.6	1,261,902.4	-130,107.2

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэл 21,891.4 мянган төгрөг нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Авлага 24,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 52,554.4 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн салбарын харьяа байгууллагуудад шилжүүлсэн 563,302.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/78 тоот тушаалаар акталж устгасан 14,952.2 мянган төгрөгийг бараа материалтай тус тус холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 86,665.7 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 2023 оны 13 болон 67 дугаар тогтоолуудаар 20,570.2 мянган төгрөгийг хөрөнгийг акталж, 10,531.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн. Мөн 106,276.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлагнасангай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 130,107.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,570,410.1 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 119,034.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,689,444.6 мянган төгрөгөөр батлагдсан нь ЗГ-ын 2023 оны 241 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчдын цалин хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 1,689,444.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,677,249.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 1,648,523.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 28,726.4 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл 97.6 хувьтай байгаа нь улсын төсвөөс 12,195.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101 ¹	922,617.4	912,754.2	-9,863.2	98.9
80802 ²	761,608.1	730,549.9	-31,058.2	95.9
83112 ³	5,219.1	5,219.1	-	-
71603⁴	1,689,444.6	1,648,523.2	40,921.4	97.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 99,817.1 мянга, сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос хандив 25,516.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 14,470.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 6,499.2 мянга, нийт 146,302.3 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан байна.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 122,123.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 24,179.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснийг татаас санхүүжилтийн авлагаар тайлагнаж Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тааилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Саруул баян уул-Аудит ХХК-ын аудитор Д.Оюунбат гүйцэтгэж, чанарын хяналтыг анхан шатанд аудитор Т.Оюун-Эрдэнэ, аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

¹ Үндсэн үйл ажиллагааны зардал

² Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал

³ Хөтөлбөр төслийн дотоод урсгал

⁴ Эрүүл мэндийн бодлого, удирдлага

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 08 дугаар албаан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,061,884.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,618.8 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,906,461.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 19,064.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн 97.6 хувийг зарцуулж, 28,726.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. Хэмнэгдсэн зардлын ихэнх хувь нь нэг удаагийн тэтгэмж урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн 29 горим сорилыг гүйцэтгэхэд тус хуулийг зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих нийт 148 мэдээллээс 1,190,800.0 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 80.2 хувьтай.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзэн зөвлөмж хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийж гүйцэтгэсэн. Завсрын аудитаар нийт 15,594.0 мянган төгрөгийн алдаа илрүүлж, асуудлын бүртгэлийг хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар биелэлтийг хянаж үзэхэд алдааг бүрэн залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 158.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/239 албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	158.0	1	158.0	100.0
Нийт дүн	1	158.0	1	158.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалтыг шалгах горимыг дараагийн аудитаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,394.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 11,917.4 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчил арилгах 8,476.7 мянган төгрөгийн албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Залруулсан алдаа

1. Нэмэлт санхүүжилтийн дансны 10,000.0 мянган төгрөгийн орлогыг байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн;
2. Нэр данс зөрүүтэй хийгдсэн 236.0 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн;
3. Акталсан хөрөнгийн элэгдлийг эрх бүхий байгууллагын шийдвэрээс 1,028.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
4. Дараа сард тооцох цалингийн авлагыг 15.0 мянган төгрөгөөр бууруулж, үр дүнгийн тайланд цалингийн зардлаар тайлагнасан;
5. Түрээсийн орлогыг дутуу бүрдүүлсэн ба бүрдүүлсэн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 537.9 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн;
6. Томилолтоор ажилласан албан хаагчид хоолны хөнгөлөлт 100.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон.

Эдгээр нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т /үнэн зөв байх/, 14 дүгээр зүйлийн 14.4-т /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.5-т /бүх орлого/ 14.4.5-т /бүх зарлага/, 20 дугаар зүйлийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/ заасныг мөн “үнэлгээ ба хуваарилалт”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 8,476.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2 албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

5.1.1 Цалингийн зардлаас албан хаагчдад 4,800.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16 дугаар зүйлийн 16.5.5-т /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1.3-т /*Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ*/, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т /*урамшуулал цалин хөлсөнд НДШ суутгагдахгүй, нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшуулал хамаарахгүй*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй"

5.1.2 Ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагийн ажилтанд илүү цагийн хөлс 3,676.7 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д /*Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно*/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т /*Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 148 мэдээллээс 1,190,800.0 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 80.2 хувьтай.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т /*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална*/, 4.1.1-т /*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*/, 4.1.2-т /*мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх*/, 4.1.3-т /*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*/ заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

"Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах"

Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хариуг 2024 оны 3 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
1. Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлогыг байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
2. Нэр данс зөрүүтэй хийгдсэн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн.	1	236.0			1	236.0	1	236.0				
3. Акталсан хөрөнгийн элэгдлийг шийдвэрээсээ зөрүүтэй бүртгэсэн.	1	1,028.5			1	1,028.5	1	1,028.5				
4. Дараа сард тооцох цалингийн авлагыг бууруулж, үр дүнгийн тайланд цалингийн зардлаар тайлагнасан	1	15.0			1	15.0	1	15.0				
5. Түрээсийн орлогыг дутуу бүрдүүлсэн ба бүрдүүлсэн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу шилжүүлсэн.	1	537.9			1	537.9	1	537.9				
6. Томилолтоор ажилласан влбан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.	1	100.0			1	100.0	1	100.0				
Дүн	6	11,917.4			6	11,917.4	6	11,917.4	6	11,917.4	-	-

2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан аудитын асуудал

Мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Үүнээс			
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалин хөлсний зардлаас албан хаагчдад түлшний хөнгөлөлт олгосон.	1	4,800.0					1	4,800.0				
Дүн	1	4,800.0					1	4,800.0				-

3. Нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс

	Тоо		Дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тогтоомжтой холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 148 мэдээллээс 1,190,800.0 мянган төгрөгийн 32 мэдээллийг байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 80.2 хувьтай.	1	0							1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагийн ажилтанд илүү цагийн хөлс олгосон.	1	3,676.7			1	3,676.7				
Дүн	2	3,676.7			1	3,676.7			1	-



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2024-02-26 № 02/141

танай _____ -ны № _____ -т

**Г ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.АЛТАНТӨГС ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлж байна. Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас



ДАРГА

Б.МӨНХТОГТОХ


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 129

Мандагловь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар цалингийн зардлаас албан хаагчдад 4,800,000.00 /Дөрвөн сая найман зуун мянган/ төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1.3-т /Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ/, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т /урамишуулал цалин хөлсөнд НДШ суутгагдахгүй, нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамишуулал хамаарахгүй/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу, төсөвтөө тусгаж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Алтантөгс, нягтлан бодогч Т.Одонсүцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Д.ОЮУНБАТ

БАТАЛГААЖУУЛСАН

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 206, 207, 210, 213 тоот
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2024-01-18 № 02/03
танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.АЛТАНТӨГС ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлж байна. Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт хуудас

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

202401028



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 02

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаар ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагийн ажилтанд илүү цагийн хөлс 3,676,672.00 /Гурван сая зургаан зуун далан зургаан мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д /Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4-т /Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно/ гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан албан үүргээ гүйцэтгэсэн ажилтанд илүү цагийн хөлс олгосон зөрчлийг таслан зогсоох;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Алтантөгс, нягтлан бодогч Т.Одонцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Д.ОЮУНБАТ

БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

вь аймгийн Эрүүл мэндийн газар

Байгууллагын РД:9034064

Аудитын код:

Аудитын нэр:

Тайланг хугацаа:

ДУА-2024/02/НА-СТА-1ШЗ

Санхүүгийн тайлангийн аудит

2023.01.01-2023.12.31

№	Ажил гүйцээний аял, дансны үлэгтэй.	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын байгууллагаас өгсөн харнуу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын холбогдох хүний		
							Албан тушаал	Овог нэр	
A	1	3	4	5	6	8	9	10	
1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл									
1.1	Орлого	Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлогыг байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	10,000,000.00	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
1.2	Орлого	Нэр данс зөрүүтэй хийгдсэн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн.	235,950.00	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
1.3	Үндсэн хөрөнгө	Акталсан хөрөнгийн элэгдлийг шийдвэрээсээ зөрүүтэй бүртгэсэн.	1,028,509.13	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
1.4	Зардлын данс	Дараа сард тооцох цалингийн авлагыг бууруулж, үр дүнгийн тайланд цалингийн зардлаар тайлагнасан	14,957.86	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
1.5	Орлого	Түрээсийн орлогыг дутуу бүрдүүлсэн ба бүрдүүлсэн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу шилжүүлсэн.	537,950.00	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
1.6	Зардлын данс	Томиллолтоор амжилласан албан хаагчид хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.	100,000.00	Заруулга хийх	зөвшөөрсөн	Заруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
			11,917,366.99						
Алдааны дүн									
удитаар илэрсэн зөрчлийн бүртгэл									
2.1	Цалингийн зардал	Цалин хөлсний зардлаас албан хаагчид тулшгүй хөнгөлөлт олгосон.	4,800,000.00	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	
2.2	Цалингийн зардал	Ажлын байрны тодорхойлолтод заагдсан албан үүргээ гүйцэтгэсэн ердийн цагийн ажилтанд явуу цагийн хөлс олгосон.	3,676,672.00	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Б.Алтантөгс, Т.Одонцэцэг	

Завсрын аудитаар илэрсэн тул 2023 оны 3 дугаар улирлын тайланд заруулсан.

Зөрчлийн дүн		8,476,672.00											
3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл													
3.1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулвал зохих нийт 148 мэдээлэгч 1,190.8сая төгрөгийн 32 мэдээллийг байршуулвал, хуудсийн хэрэгжилт-80.2 хувьтай.												Б.Алтангөгс, Т.Одонцэцэг
Дүн													
Нийт алдаа зөрчлийн дүн		20,394,038.99											

эн: Аудитор
аудитын менежер
үлэх аудитор

/Д.Оюунбат/
/Х.Наранцрал/
/Р.Мөнхтогтох/
Огноо: 2024.02.21
Огноо: 2024.02.21
Огноо: 2024.02.21

Тангшдаж, зөвшөөрж:
Дарга
Нягтлан болдогч
/Б.Алтангөгс/
/Т.Одонцэцэг/

Огноо: 2024.02.21
Огноо: 2024.02.21

